

НИЙТЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

М. Я. СУШАНЛО

Зөвлөлт Социалист Киргиз улсын ШУА-ийн Дорнодахины судлалын хэлтсийн эрхлэгч, түүхийн ухааны доктор

КИРГИЗ ДЭХ ДОРНОДАХИНЫ СУДЛАЛ

Дорнодахины судлалын нэгэн салбар болох Дунган судлал нь Киргизийн Дорнодахины судлалд чухал суурийг эзэлдэг юм.

Дунганчуудын ихэнхи хэсэг нь (хуэй) хятадад нутагладаг. Зүүн Өмнөд Азийн зарим орнууд жишээлбэл, Бирм, Индонез, Сингапур зэрэг улсуудад (хуэйцзу) буюу хятадын мусульман гэж нэрлэгдэх цөөн тооны дунганчууд амьдарч байна.

Хятадын хүн ам зүйчдийн мэдээнээс үзвэл хятадад нилээд хэдэн сая дунганчууд амьдарч байна. Гэвч хятад дахь дунган хүн амын тооны талаархи статистикийн баримтууд өөр өөр байдаг юм. Нэг хэсэг нь Хятадад 20-30 сая дунганчууд амьдардаг гэж, үзэж байхад нөгөө хэсэг нь 5-10 сая гэж үзэж байна. Одоогийн байдлаар БНХАУ-д 6 сая гаруй дунганчууд амьдарч байна.

1953 оны хүн амын тооллогод үндэслэн 1957 онд Бай Шоуй, Хань Дожэнь и Дин Иминь¹ нарын зохиосон БНХАУ дахь дунгаан хүн амын тархалтын таблицаас үзэхэд дунгаанчууд Хятадын бүх нутгаар тархан амьдардаг боловч Ганьсу, Хэнань, Хэбэй, Цинхай, Шаньдунь, Юньнань зэрэг мужуудыг дунгаан ястан оршин суудаг хятадыг гол районууд гэж үзэж болно.

Дунганы ард түмний өвөрмөц ахуй амьдрал, түүх соёлын баялаг өв уламжлал дорнодахинч-судлаачдын анхаарлыг эртнээс нааш татсаар иржээ. Оросын жуулчин, Хятад судлаач эрдэмтэн нар дунганчуудын тухай анхны үг үсгийг шинжлэх ухаанд оруулсан (өөрсдийн нэр нь-лаохуай-хуэн буюу Чжун Юань жэнь) билээ. Тэд эрдэм шинжилгээний су-далгаа, өгүүлэл, тэмдэглэлдээ Хятад дахь дунган хүн амын ахуй амьдрал, түүхтэй уншигч олныг танилцуулсан байна. Чухамхүү оросын ном зохиолоор дамжуулан өрнөдийн хятад судлаачид хятадын ястангуудын нэг дунганчуудтай танилцсан болно. Оросын жуулчид, эрдэмтэд дунганчуудын тухай анх удаа бичиж шинжилгээ судалгааны нилээд хэдэн асуудлыг боломжийнхоо хирээр шийдвэрлэхийг хичээсэн юм.

Дорнод Туркистаны хүн ам, тухайлбал дунганчуудын тухай хамгийн эртний мэдээг бид оросын жуулчдын мэдээнүүдээс олж үзэж байна. 1819 онд «Сибирийн мэдээ»²-д хэвлэгдэн гарсан Путимцевын Бухтарминын цайзнаас Кульджи хот хүртэлх 1811 оны аялалын тухай өдрийн тэмдэглэлд Кульджи болон түүний ойролцоох нутагт амьдарч газар тариалан, жижиг худалдаа эрхэлж байсан тунганчууд (дунганчууд) бай-

¹Бай Шоуй, Хань Дожэнь, Дин Иминь, Хуэй-хуэй миньцзуди цзяньши хэ сянь чжуань-Пекин. 1957. с. 11. Люй Чжэньюй; Чжунго миньцзу пзяньши-Пекин, 1951, с 100

²Сибирский вестник, ч. VII—VIII, СПб, 1819

сан тухай бичсэн байдаг. Путилцев тунганчууд бол суннийн мусульманууд бөгөөд хятад аялгаар ярьдаг болох тухай бичсэн байна.

1855 оны «Оросын газарзүйн нийгэмлэгийн бичгүүдэд»³ Дорнод Туркистаны дунганчуудын мэдээ баримтууд бий.

Дунганчуудын тухай мэдээ 1950-60-аад онуудад үлэмжхэн гарсан бөгөөд энэ нь Хятад дахь үйл явдал, чухамхүү Юньнань, Шэньси, Ганьсу, Синьцзян мужуудад дунганчууд Чин улсын эсрэг болсонтой холбоотой.⁴ XIX зууны II хагаст Хятадын баруун хойт районуудад болсон дунганын бослогын түүх бол тариачин олон түмний их удирдагч М. Л. Байяньхугийн нэртэй холбоотой юм.⁵ Түүний нэр дунганы ард түмний түүхэнд үндэсний баатар, өөрийн ард түмний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө Чин улсын үеийн хятадын дарангуйлалын эсрэг эвлэршгүй тэмцэгч болон үлдсэн билээ. Чин улсын үеийн Хятадын дарлалын эсрэг Дунганы ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн бол орос, зөвлөл- тийн бөгөөд хятадын ном зохиолуудад шинжлэх ухааны судалгааны объект болж байгаа юм.

Нэрт хятад судлаач П. И. Кафаровыи (Палладий) «Хятад дахь лалын шашины» тухай хэмээх зохиол «Бээжин дэхь оросын шашны номлолын бүтээлүүдэд» гарсан юм. Зохиогч ихээхэн баримтат материалд тулгуурлан хятадад лалын шашин нэвтэрсэн цаг үе, тархсан явц, явцуу бүлэглэлийн хөдөлгөөний тухай өгүүлжээ.

Кафаровын дараа хятадын дунган ястанг судалсан хүн бол Оросын нэрт хятад судлаач Академич В. П. Васильев билээ.⁶ Түүний бүтээлүүд нь хятадад дунган ястан бүрэлдэн тогтсон түүхийг судлахад шинжлэх ухааны ихээхэн үнэ цэнэтэй юм. Түүнчлэн хушууны эмч Пржегодский, бага эмч В. М. Фрунзе (Улаан армийн жанжин, пролетарийн хувьсгалч М. И. Фрунзийн эцэг) нарын үзүүлж байсан тусламжийг тодруулсан В. И. Поярковын «Дунганчуудын бослогын сүүл үе» ном одоо ч хүртэл шинжлэх ухаан, эх бичиг судлалын үнэ цэнээ алдаагүй юм.⁷ Энэ ном хятад судлалын ном зохиолын дотор Дунганын баатар Байяньхугийн намтар түүхийг түүний ойр дотны нөхөд төрөл төрөгсөдөөс лавлаж бичсэн бараг цорын ганц зохиол болжээ.

Хятад судлалын ном зохиолд хятад дахь дунган ястны гарал үүслийн тухай нилээд хэд хэдэн таамаглал байдаг. Жишээ нь: Араб-персид, турк, уйгурын болон зөвхөн хятад гаралтай гэх зэрэг хэд хэдэн таамаглал оршиж байсан юм.⁸

Хятад (хан), дунган (хуэй) нар нэгэн ерөнхий гарал үүсэлтэй болох тухай онол хүчин төгөлдөр бус гэдэгт анхаарлаа хүчтэй болгох нь чухал гэж бид үзэж байна. Чин улс, гоминьданы ноёрхлын үед Хятадад энэ онол ихэд газар аван дэлгэрч байжээ. Гоминьданын «Сицзин пинь-

³Записки императорского Русского географического общества. СПб 1855, Кн. X

⁴Бай Шоуи, Хуэйминь ций, в 4-томах. Пекин, 1952, Линь-Гань Циндай Хуэй цзу Цийн.— Шанхай. 1957. Ма Сяоши, Сибэй Хуэйцзу гаминь цзяньши. Шанхай, 1952, Дуан Цзи. Сибэй хуэйцзуди фаньцин данчжан.—Шанхай 1957, Сушанло М. Я. Дунганское восстание второй половины XIX в. и роль в нем Бай Яньху-Фрунзе, 1959. Поярков Ф. Последний эпизод дунганского восстания.— Верный, 1901 и др.

⁵Грум Гржимайло. Дунганский партизан Да-ху или Баянхур. Исторический вестник, 1891, № 5—6, Думан Л. И. Баянху-вождь дунганского восстания. Записки Института Востоковедения АН СССР, 1839, № 7. Сушанло М. Я. Борьба дунган против Цинской династий, Ученые записки Тартусского Государственного университета, 1979, Дунгановедение, № 507 и др.

⁶Васильев В. П. О движениях магометанства в Китае.—СПб. 1867.

⁷Поярков Ф. В. Последний эпизод дунганского восстания—Верный, 1901.

бао» сонинд «манай лалын шашинтнууд (дунганчууд-М.С) эх орон нэгтэнгүүд хятадууд нэг өвөгтэй нэгэн арьстангууд юм»⁹ гэж бичиж байсан ажээ. Энэхүү их хан улсын үндэсний дээрэнгүй онол дунганчуудын гарал үүслийн тухай «Хуэйхуэй юань лай», хэмээх нэрийн дор засварлан хэрэглэгдэж байсан домогт тулгуурласан ажээ. Үүний тайлбарыг Оросын Хятад судлаач П. И. Кафаров өөрийн «Лалын шашинтны хятад ном» хэмээх номондоо бичжээ.¹⁰

Хятадын үндэсний дээрэнгүй үзэлтнүүд энэхүү их хан үндэстний номлолыг уусган залгих бодлогодоо ашигласаар ирсэн бөгөөд одоо ч ашигласаар байгаа юм. Хятад дахь дунганчуудад улсын хэмжээгээр нэрээ хэрэглэхийг хорьж, «ерөнхий хэл соёл» хэмээх лоозонгийн дор үндэсний ахуй зан заншлын онцлогийг устгаж, шашин шүтлэгийг доромжлон лалын сүм хийд, оршуулгын газрыг бузарлан гутааж байсан юм. Албан ёсны баримт бичигт дунганчуудад Гуаньмин гэдэг албан ёсны нэртэй байхыг зөвшөөрч үндэсний нэрийг бүрэн хоригложээ. Жишээлбэл, дунганчуудад Ван Лоэр, Дин Гоминь, Ма Мин-янь, Бао Лоза, Ха Чу-чэнь гэх зэрэг ерөнхий хан маягийн овог нэртэй байхыг зөвшөөрч байжээ. Ийм овгоор дунган, дуноян, мио болон бусад ястангуудыг хятадуудаас ялгахын аргагүй байв. Нэгдсэн овог хэрэглэсэн явдал нь их ханы үндэсний дээрэнгүй үзэлтнүүдэд хан биш ард түмнийг уусгах бодлогоо явуулах боломж олгож байсан юм. Улиг домог болсон нэгдмэл овог нь үндэстний дээрэнгүй үзэлтнүүдэд мөн л улс орон даяар хятад биш үндэстнүүдийн тоог санаатайгаар дарах боломж олгожээ.

БНХАУ оршин тогтнож байсан анхны жилүүдэд тус оронд хятад дунганчуудын гарал үүслийг нэг болгох тухай онол хэд хэдэн удаа хэлэлцэгдэж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Зөвлөлтийн дунган судлаачид дунганчуудын овог дээдсийг тогтоохдоо антропологийн судалгаа, ахуй хэл, соёлын материалд тулгуурласаар ирсэн бөгөөд одоо ч үүнд түшиглэж байдаг юм. Зөвлөлтийн антропологчид (Г. Ф. Дебец, М. Г. Левин, Н. Н. Чебоксаров) Дунганчуудыг алс дорнодын «монголоид» арьстанд хамааруулан үзэж байна. Гэвч дунганчуудын дунд хамрын хэлбэр, хянгын өндөр нүүр толгойн үсэн бүрхүүл, ялан гуяа сахал ихээхэн хөгжсөн зэрэг европжуу төрхтэй хүмүүс ихээхэн байдаг юм. Г. Ф. Дебец, М- Г. Левин нар эдгээр шинж төрийг дунганчуудад Иран, Дундад Азийн хүмүүсийн төрх байгаагийн үр дүн гэж үзэж байсан билээ.

Тийнхүү антропологийн хэл ахуй, оюуны соёлын баримт материал дунганчуудын гарал үүсэл, хөгжлийн тухай асуудал үлэмжхэн ээдрээтэй болохыг гэрчилж байна. Зөвлөлтийн дунган судлаачид дунганчуудыг гарал үүслийн хувьд ихээхэн ээдрээтэй зам туулсан гэж үздэг юм.¹¹ Дунганчуудын гарал үүсэлд орон нутгийн хүн ам гол үүрэгтэй байжээ гэж бид үзэж байна. Энэ үндсэн бүрэлдэхүүнд нөлөөлсөн давхрага хэсэг бол

⁸См: Сушанло М.Я., Стратанович Г.Г. К вопросу о происхождении дунган, В кн. Очерки истории советских дунган. Фрунзе, 1967: Линь Гань. Об этногенезе дунган Советская этнография. 1954, № 1. Стратанович Г.Г. Краткая справка о происхождении дунган. Советская этнография. 1954, № 1.

⁹Сицзинь пиньбао, 1958,—2 февраля

¹⁰Палладий Китайская литература магомтан. СПб; 1887, с 25—27.

¹¹Народы Восточной Азии (Под ред. Н.Н.Чебоксарова, С.И.Бука, Р.Ф.Итса, Г.Г.Стратановича—М.Л. 1965, с. 419—433, Народы Средней Азии и Казахстана (Под ред. С.П.Толстого, Т.А.Жданко А.С.Абрамзоно, Н.А.Кислякова, т. 2. —М., 1963 с, 527—563

дунганчуудын гадаад төрх байдал дахь ялгаа, үндэсний болон ахуй, соёл тэрчилэн хэл ярианы өвөрмөц онцлог байдлыг гэрчилж буй хэрэг юм.¹²

Хэдийгээр материал баримтууд байсан авч дунган эрдэм судалгааны объект болж чадаагүй байсан бөгөөд ийм ч учраас дунганчуудын түүх, хэл соёлын талаар нэгтгэн бичсэн нэг ч бүтээл бидэнд байгаагүй юм.

Зөвхөн агуу их Октябрийн социалист хувьсгал ялснаар ЗСБНХУ, Хятадын жижиг ястан, үндэстний, цөөнхүүдийн нэг болсон дунганчуудын ахуй соёлыг судлах боломж нээгдсэн билээ.

Эдүгээ дунган судлал Зөвлөлтийн дорнодахины судлалын нэгэн салбар болсон төдийгүй түүний хөгжилд дунган эрдэмтэд чухал роль гүйцэтгэж байна.

30-аад онуудад Москва, Ленинградын дорнодахины судлалын төвүүд дунганчуудыг судлах асуудлыг дэвшүүлэн тавьсан билээ. Зөвлөлтийн нэрт хятад судлаач академич В. М. Алексеев, профессор Е. Д. Поливанов, А. А. Драгунов нар авиан зүйн бичиглэл зохиож нэвтрүүлэхэд ихээхэн тусламж үзүүлсэн болно.

Дунган хэлийг судлахад анхны тулгын чулууг тавилцсан хүн бол Александр Александрович Драгунов¹³ бөгөөд тэрээр дунган хэл судлахын зэрэгцээ үндэсний боловсон хүчин бэлтгэх талаар ихэд ажилласаи билээ. С. Е. Яхонтов «А. А. Драгунов бол нэртэй дунган судлаач, онолч төдийгүй өөрийн шинжилгээ судалгааны ажлынхаа бүх л хугацаанд Зөвлөлтийн Дундад Азийн дунганчуудтай дотно холбоотой ажиллаж дунган утга зохиол, хэвлэлийн ажил хөгжүүлж төрөлх хэлээр эхлэн сурах зэрэг үндэсний соёлыг сэргээн босгоход ихээхэн тус дөхөм үзүүлсэн»¹⁴ гэж туйлын зөв бичсэн байна.

Дунган хэл судлалын хөгжилд хүндтэй байруудын нэгийг эзлэх хүн бол 30-аад онд Фрунзе хотод ирж ажиллаж байсан томоохон эрдэмтэн дорнодахинч Евгений Дмитриевич Поливанов¹⁵ билээ. Тэрээр дунган хэлний талаар нилээд хэдэн судалгааны материал хэвлүүлсэн нь дорнодахины судлалын ном зохиолд нилээд үнэлэлт авчээ. Е. Д. Поливанов мөн А. А. Драгуновын нэгэн адил дунган ястнаас эрдэм шинжилгээний боловсон хүчин бэлтгэхэд идэвхтэй оролцож байсан байна.

1930-аад оны эхэнд проф. П. И. Фесенкогийн удирдсан ЗХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн тусгай шинжилгээний анги Дундад Азийн дунганчуудад зориулагдан гарсан юм.

Дунганчуудыг соёлоо хөгжүүлэхэд тусламж үзүүлэх явдал шинжилгээний ангийн үндсэн зорилт нь болж байсан юм. Шинжилгээний ангид оролцогчдоос Дундад Азийн дунганчуудын тухай эрдэм шинжилгээний өгүүлэл, төв орон нутгийн хэвлэлүүдэд нийтлүүлжээ. Тухайлбал, проф. Г. И. Фесенко Дунганы соёлын төвшинг дээшлүүлэх, дунган судлалын төв байгуулах арга хэмжээний тухай саналаа ихээхэн хэмжээний баримт материалын хамт Киргизийн эдсгийн газар бэлтгэн өгчээ. Шинжилгээний ангийн материалд тулгуурлан Б. А. Васильев¹⁶, Л. И. Думан¹⁷

¹²Сушанло М. Я. Дунгане—Фрунзе. 1971, с. 41—79.

¹³Драгунов А. А. Дунганский язык. Записки Института Востоковедения АН СССР, т. VI., 1937, его же Исследования в области дунганской грамматики— М—Л., 1940.

¹⁴Краткое сообщение Института Востоковедения АН СССР. М. 1965 вып. XVII

¹⁵Поливанов Е. Д. Статьи по общему языкознанию—М., 1968.

¹⁶Васильев Б. А. Дунгане «из материалов дунганской экспедиций Культура и письменность Востока 1931, № 7—8.

¹⁷Записки Института Востоковедения АН СССР, т. VII, 1939., Библиографня Востока, 1935., № 7.

нар хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж дорнодахины судлалын хэвлэлүүдэд хэвлүүлсэн нь шинжилгээ судалгааны аятайхан үнэлэлт авсан байна.

1940-өөд онд ЗХУ-ын Н. Н. Микухо-Маклайн нэрэмжит этнографийн хүрээлэн Киргизийн дунганчуудад хэд хэдэн удаа шинжилгээний анги зохион явуулж судалгаа хийсэн байна. ЗХУ-ын ШУА-ийн этиографийн хүрээлэнгийн бүтээлүүдэд дунганчуудын тухай хэд хэдэн дорвитой эрдэм шинжилгээний өгүүллүүд хэвлэгдсэн байна.¹⁸ Энэхүү шинжилгээний ангийн материалууд дунганчуудын эд өлгий, оюуны соёлыг судлахад чухал эх сурвалж нь болж байна. Эдгээр дээр дурдсан ажлуудын зарим нь дунган ястны гарал үүслийн тухай зарим асуудлуудыг хөндөж судлахад ихээхэн ач холбогдолтой болсон байна.

1950-аад онуудад шинэ бичиг зохиох зайлшгүй шаардлага гарсан үед (орос үсгийн үндсэн дээр) Киргизийн эрдэмтэд ЗХУ-ын ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар хавдаж энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд дорно дахинч эрдэмтдээс бүрдсэн комисс байгуулж өгөх хүсэлт тавьсан бөгөөд уг асуудлыг Москва, Ленинград, Киргиз, Казахстаны эрдэмтэд амжилттай шийдвэрлэсэн юм. Эдүгээ энэхүү бичгээр Зөвлөлт Киргизид төрөлх хэлнээ улс төр, уран сайхны болон сургалтын ном зохиол хэвлүүлж, мөн «Шыйуэди чи» (Октябрийн туг) сонин гаргаж байна.

Хэдийгээр Москва, Ленинградын Дорнодахиныг судлах төвүүд дунганыг судлах асуудалд сонирхол, анхаарал тавьж байсан боловч хэл, утга, зохиол, түүх этнографийн судлал тохиолдлын шинж чанартай байсан байна,

Гагцхүү 1954 онд Зөвлөлт Социалист Киргиз улсын ШУА-ийн системд дунган судлалын соёлыг судлах тусгай сектор байгуулснаар дунганы судлалын асуудал бол төлөвлөгөөт судалгааны объект болсон юм. Энэ хугацаанд дунган судлаачид дунганчуудын түүх,¹⁹ этнографи,²⁰ хэл ярианы²¹ талаар ихээхэн сонирхолтой эрдэм шинжилгээний бүтээлүүд нийтлүүлсэн нь манай оронд төдийгүй хилийн чандад нааштай үнэлэлт авлаа.²³

Зөвлөлтийн дунган судлаачдын бүтээлүүдэд өнгөрсөн жилийн судлагдадгүй материалыг нөхөн судалж байна. Эдүгээ судлаачдын ихэнхи нь дунган ястны төлөөлөгчид байгаа юм. Энэ бол Зөвлөлт Киргиз, Казахстаны намын байгууллагууд дунган үндэстний боловсон хүчин бэлтгэхэд их анхаарал тавьсаны илрэл бөгөөд энэ нь зөвлөлт засаг, ЗХУКН-аас үндэстний цөөнхийн соёлыг хөгжүүлэхэд их анхаарал тавьж байдагтай холбоотой.

ЗСБНХУ-ын нийгэм эдийн засгийг 1982-1985 он улмаар 1990 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай ЗХУКН-ын XXVI их хурлын тогтоолд коммунизмын эсрэг үзэл, нийгмийн хөгжлийн тухай хөрөнгөтний болон ревизионист номлолыг шүүмжилж марксизм-ленинизмыг завхруулагчдыг уудлан илчлэхийн чухлыг заасан билээ.

¹⁸Краткое сообщение Института этнографий АН СССР., М., 1949, т. XXVI.

¹⁹Очерки историй советских дугган (Под ред. М. Я. Сушанло и Г. Г. Стратановича Фрунзе, 1967 Юсупов. И. И. Советские дуггане в период строительства социализма-Фрунзе 1977 и др,

²⁰Сушанло М. Я Дуггане (исюрико-этнографический очерк) Фрунзе. 1971.

²¹Имазов М. Х Фонетика дунганского языка-Фрунзе 1975, его же Орфо- графия дунганского языка. Фрунзе. 1977 и др.

²²Красакеев К. К. Успехи советского дуггановедия. История СССР. 1968, № 5, Ильясов С. Плоских В. М Шинло л, Важный вклад в дуггановедение, советская Киргизия, 1971, 12 октября,

Эдүгээ Киргизийн Дорнодахины судлаачид Москва, Ленинград, Алма-Ата, Ташкент, Душанбегийн үзэг нэгт эрдэмтэдтэйгээ хамтран Чин улс, Гомнньданы дэглэм, харгис Маоизм их хан үндэстний дээрэнгүй үзэл, жанжлалын эсрэг хятад биш үндэстнүүдийн үндэсний эрх чөлөөний тэмцлийн салбар дахь асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажилласаар байгаа бөгөөд ажиллах ч болно. Хамгийн гол нь их хан үндэстний ивээлийн дор «Хятадын ард түмэн ерөнхий гарал үүсэлтэй болох тухайн маоист онол хүчин төгөлдөр бус хийгээд түүний марксизм-ленинизмийн эсрэг мөн чанарыг гарган үзүүлэх нь чухал байгаад л оршино. Түүнчилэн дунган судлаачид бид Дундад Ази, Казахстан, Зүүн (Дорнод) Азийн дунганчуудын хэл яриа, түүх соёл, угсаатны судлалыг асуудлыг хөндөн боловсруулах болно.

Зөвлөлт Социалист Киргиз улсын шинжлэх ухааны Академиас дунган судлалын асуудлыг цаашид боловсруулах явдал бол ЗХУКН-ын XXVI их хурлын түүхэн шийдвэрийг амьдралд хэрэгжүүлж байгааг гэрчилэх болно. Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежнев Лениний намын XXVI их хурлын индрээс «сүүлийн жилүүдэд хэд хэдэн Бүгд Найрамдах улсуудад уугуул нутгийн биш үндэстнүүдийн хүн ам үлэмжхэн өслөө. Тэд хэл, яриа, соёл ахуйн салбарт өөрсдийн өвөрмөц эрэлт хүсэлттэй байдаг юм»²⁴ гэж хэлсэн билээ.

Зөвлөлт Киргиз улсад үндэсний цөөнхүүдийн шинжлэх ухааны соёлын эрэлт хүсэлтийг хангах талаар ихээхэн хэмжээний туршлага хуримтлуулсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, Киргизийн Коммунист нам, засгийн газар, Киргизийн ард түмэн дунган хэлний авиан бичиглэлийг боловсруулах, сургалт, урлаг, улс төрийн ном зохиол хэвлэх, төрөлх хэлнээ сонин сэтгүүл гаргах, түүнчилэн шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх салбарт боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Дунган судлаачид цаашид Зөвлөлтийн нам, ард түмний өндөр итгэл найдварыг биелүүлэхийн төлөө урьдын адил бололцоотой бүхнийг хийх болно.

Орос хэлнээс орчуулсан **Д. Оюунчимэг.**

²³ Советская этнография, 1972. № 3. (рецензия на кн. Дунгане).

²⁴ Л. И. Брежнев. Отчётный доклад ЦК КПСС XXVI съезду КПСС и оче- редные задачи в области внутренней и внешней политики—М., 1981, с 68.